

**“АЧИТ АЛХАБЫ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дугаар  
сарын 30 өдөр

Дугаар 05

Өлгий сум

Компанийн 2022 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, компанийн дүрмийн 7.32.5 заалтыг үндэслэн “Ачит Алхабы” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Ачит Алхабы” хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн тухай ТУЗ-өөс оруулсан илтгэлийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч удирдлагаар ханган ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА ..... К.АХЖАРХЫН

## “АЧИТ АЛХАБЫ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дугаар  
сарын 30 өдөр

Дугаар 06

Өлгий сум

2023 оны төлөвлөгөө, төсөв  
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дэх заалт, компанийн дүрмийн 7.32.2 заалтыг удирдлага болгон Тооллолгын комиссын тооллолгын дүнг үндэслэн “Ачит Алхабы” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Ачит Алхабы” хувьцаат компанийн ТУЗ-өөс оруулсан 2023 оны төлөвлөгөө, төсвийг баталсугай.
2. Компанийг удирдах үйл ажиллагаандаа Компаний тухай хууль болон Хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж төлөвлөгөөт зорилтыг хэрэгжүүлэн ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  ХАХЖАРХЫН



## “АЧИТ АЛХАБЫ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

... 2023 оны 04 дугаар  
сарын 30 өдөр

Дугаар 07

Өлгий сум

Компанийн ТУЗ-ын гишүүнд  
нэр дэвшигчдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 94.2, 94.3, 94.4 дугаар зүйлийн заалтыг, компанийн дүрмийн 7.32.2 заалтыг удирдлага болгон Тооллолгын комиссын тооллолгын дүнг үндэслэн “Ачит Алхабы” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Ачит Алхабы” хувьцаат компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Халым овогтой Калимат, Калимат овогтой Ахжархын, Калимат овогтой Алуа, Калимат овогтой Али нарыг баталсугуй.
2. “Ачит Алхабы” хувьцаат компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Халым овогтой Халамхан, Түгелбай овогтой Далелхан, Азкей овогтой Еркеш, Ерлан овогтой Жанбота, Бахыт овогтой Айтолхын нарыг баталсугуй.

ХУРЛЫН ДАРГА  АХЖАРХЫН